



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 1/545

Чойбалсан

Г Захирамжийн хавсралтад өөрчлөлт 7
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, "Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 3.2.9, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03/02 дугаар тогтоолоор батлагдсан "Дорнод аймгийн 2025 оны Хөгжлийн жилийн төлөвлөгөө"-ний 4.2.1.5 дахь заалт, "Аймгийн 2025 оны төсөв батлах тухай" 03/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Дорнын хүчтэн дэвжээ" Нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн "Үндэсний бөхийн спортыг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх тухай" аймгийн Засаг даргын 2025 оны А/85 дугаар захирамжийн хавсралтад өөрчлөлт оруулсугай.

2. Дэмжлэгт шаардагдах 20,000,000 (хорин сая) төгрөгийг аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтын 2.25 дахь заалт "Үндэсний бөхийн спортыг хөгжүүлэх" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (П.Бат-Өлзий)-д зөвшөөрсүгэй.

3. Хөтөлбөрийг чанартай зохион байгуулж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан, үр дүнг олон нийтэд танилцуулж ажиллахыг аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга (Б.Чимэддорж)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ч.Ганбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ш.ЁЛ



Аймгийн Засаг даргын 2025 оны
11 дүгээр сарын 07 ны өдрийн
1/545 дугаар захирамжийн хавсралт



ҮНДЭСНИЙ БӨХИЙН СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ДЭД ХӨТӨЛБӨРИЙН
2025 ОНЫ ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Зардлын төрөл	Барилдааны тоо	Хүний тоо	1 хүний зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)
1	Идэрчүүдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах	1	200	2,000,000	2,000,000
2	Сумын цолтой бөхчүүдийн барилдаан	1	64	2,600,000	2,600,000
3	Аймгийн цолтой болон цолгүй бөхчүүдийн барилдаан	1	64	2,000,000	2,000,000
4	Тэмдэглэлт ойн нэрэмжит барилдаан зохион байгуулах	1	64	2,400,000	2,400,000
5	Өсвөрийн бөхийн "Үе чацуутан" тэмцээн	1	600	1,000,000	1,000,000
6	"Дорнын хүчтэн" дэвжээний үйл ажиллагааны зардалд дэмжлэг	1	192	10,000,000	10,000,000
НИЙТ ДҮН					20,000,000

---oOo---

۱) ره‌یوونکون دڼ ځنځاڼن لمرنگه وځنځاڼو ، وځمپسرسره ځمدرغو د لمانځنمېډر لډر ځنځو لمانځنمېډر ،
پمډر ځمځاڼ د پمېډر ځنځاڼ ځو ځنځاڼمېډو پمځپسو دڼ پمځپسر مډ وډر ځنځاڼ لډر ځمځاڼ ، پمځاڼ مډ ځنځاڼ مډ ځمځاڼ
(و-ځمځاڼمځاڼ) ځو ځنځاڼمېډر مځنځاڼ ..

۲) لمرنگه لډر لمرنگه ځو لمرنگه ځمځاڼمېډو لمرنگه لډر لمرنگه مډ لمرنگه ځمځاڼمځاڼ لډر پمځپسر
(ځ-ځمځاڼمځاڼ) ځو پمځاڼ مځنځاڼ ..

ځمځاڼ مځنځاڼ



ځمځاڼ مځنځاڼ